



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 12

Номгон

┌ Албан тушаалын сул орон тоонд ┐
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.4, 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэ оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтын тайланг хянан үзээд сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан П.Тогтохжаргалыг Гурванбулаг сумын ИТХ-ын Нарийн бичгийн даргаар, М.Баярбаясгаланг Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн даргаар, Г.Одгэрэлийг Эм, эмнэлгийн хэрэгсэл вакцин биобэлдмэлийн хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, А.Булганчимэгийг Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтнээр, Б.Бямбадуламыг Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнээр, Б.Хүрэлчулууныг Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтнээр, Н.Мөнхсолонгыг Биеийн тамир спортын газрын Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтнээр тус тус томилуулахаар нэрийг дэвшүүлсүгэй.

2. Төрийн албаны тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авч сул ажлын байранд нэр дэвшигдсэн иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22.1.3, 22.1.5-д тавигдсан шаардлагыг хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаас авч хянахыг холбогдох байгууллагын дарга нарт сануулсугай.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд зөвлөсүгэй.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

642213145